

Үндэстэн угсаатан хоорондын сөргөлдөөнүүд янз бүрийн учир шалтгааны холбоотойгоор үүсдэг болохыг түүхэн эх сурвалжаас олж харж болхоос гадна өнөөгийн Монголын нийгмийн нэгээхэн далд хэлбэрийн үзэгдэл болсоныг мөн тодотгож болно. Гэтэл өнөөгийн Хорих ял эдлүүлэх ажиллагаанд үндэстэн, угсаатны хоорондын харилцааны онцлогийг харгалзсан ойлголт, зохицуулалт байдаггүй бөгөөд угсаатны сэтгэл зүйн онцлог, адилсалт ялгаа харилцан хамаарал сөрөг хандлага нь өнөөгийн хорих байгууллагын практикт тулгардаг гэмт хэрэг, зөрчил сөрөг үр дагварын үндэстэй холбоотой байхыг үгүйсгэх аргагүй юм.

Хэдийгээр угсаатны онцлог, тодорхой ялгааг нийгмийн хандлагаар харилцан адилгүй байдлаар тодорхойлон дүгнэн хэвшмэл хэллэг болсон хэдий ч энэхүү харилцан хамаарал адилсалт, ялгааг хорих ял эдлүүлэх практик үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр анхааран үйл ажиллагаандаа тусгалыг нь олж ялтныг хорих ангид хуваарилах, шилжүүлэх, мөн хорих өрөөнд хуваарилах зэрэг ажиллагаанд харгалзан, анхааран авч үзэж байх нь зүйтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ХСИС-ийн	Шүүхийн
шийдвэр	гүйцэтгэлийн
сургуулийн	Шүүхийн
шийдвэр	гүйцэтгэлийн
процессийн	эрх зүйн
тэнхмийн	ахлах багш,
дэслэгч	

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААРХИ ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ
БУЙ ЗАРИМ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор 2002 онд УИХ-аас Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр Үндсэн хуульд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн баталгааг төр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон хуулийг батлан гаргасны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Шинээр батлагдсан энэхүү хуулийн үзэл баримтлалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулахаар заасан байна. Энэ хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбогдсон нийгмийн тодорхой харилцаа зохицуулагдаж байна. Ийнхүү Монгол Улсын үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсөн эрхээ сэргээлгэн шийдвэр, магадлал, тогтоол гаргуулдаг. Энэхүү

гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгддэг. Иймд ИХШХШТХ –ийн 18-р бүлэг нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” хэмээн нэрлэгдэж, шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийн эрх зүйн зохицуулалтыг баталгаажуулсан. Энэ нь өөрөөр хэлбэл иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ИХШХШТХ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тус, тус зохицуулж байна гэсэн ойлголт юм. Судлаач миний зүгээс энэхүү илтгэлдээ хэн бүхний анхаарлыг байнга татаж байдаг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэн хуулийн этгээдүүдийн хооронд зөрчилдөөнтэй асуудлыг бий болгодог хөдлөх болон, үл хөдлөх эд хөрөнгийн маргаан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал урамшуулал, гүйцэтгэх баримт бичигтэй холбоотой гомдол санал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогчдын зүгээс хууль хэрэгжүүлэх үүрэгээ биелүүлэхэд гардаг тулгамдсан хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг энэхүү илтгэлээрээ дэвшүүлэн тавихыг зорьлоо.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа гэдэг нь иргэний хэргийн талаарх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа ойлголт юм. Шүүхээс гарсан шийдвэр, мөн түүнчлэн шүүхээс баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад шийдвэр гүйцэтгэх байгууллага ба тус ажиллагаанд оролцогч бусад субъектийн хоорондын үйл ажиллагааны нийлбэр. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах явцад үүссэн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны нийлбэр мөн гэдэг байдлаар тус тус

тодорхойлох нь эрх зүйн үндэслэлийн хувьд бодит байдалд илүү тохирох ойлголт юм.³⁷

Иймээс иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өвөрмөц онцлог бүхий үе шатуудыг тодруулан авч үзэх нь зүйтэй байх.

1. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцогч субъектүүдын хувьд онцлогтой. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, ажиллагаанд заавал байх субъект нь шүүх бөгөөд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсэж бий болох харилцаа шүүхээр дамжиж бий болдог. Тэгвэл иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд заавал оролцох субъект нь шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч бөгөөд төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх, үүрэг энэ байгууллагаар дамжин хэрэгжиж байдаг онцлогтой.

2. Эдгээр харилцааг зохицуулж буй эх сурвалжаараа ялгагдах онцлогтой. Тухайлбал: нэхэмжлэлийг хүлээн авах иргэний хэрэг үүсгэх ажиллагааг ИХШХШТХ-аар зохицуулж байгаа бол төлбөр төлөгчийн орон байранд нэвтрэн орох, үзлэг нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураан авах гэх мэт ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх дагнасан хуулиар зохицуулж байх жишээтэй.

3. Эдгээр эрх зүйн зохицуулах зүйлийн хууль зүйн үр дагавар нь өөр байдаг. Тухайлбал: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн зорилго нь шүүхийн шийдвэрийг бодитойгоор биелүүлэхэд оршдог. Эдгээр онцлогууд нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллагын бүтэц зохион

³⁷ А. Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он

² С.Нарангэрэл “Дэлхийн ба монголын эрх зүйн тогтолцоо” УБ 2004 он

байгуулалт, чиг үүргийг боловсронгуй болгоход ач холбогдолтой байж болох юм.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч чухал үүргийг гүйцэтгэдэг учраас тэдний бусдаас хараат байж, гүйцэтгэлийн ажиллагааг түргэн, шуурхай, нээлттэй явуулахад мөрдөх хууль тогтоомж дүрэм заавар гэх мэт эрхийн актууд нь хэрэглэхэд ойлгомжтой, хоёрдмол санаа агуулаагүй, гүйцэтгэх арга хэмжээг нарийн зохицуулсан байх нь чухал гэж үзэж байна. Шийдвэр гүйцэтгэгч төрийн нэрийн өмнөөс бусдын өмч хөрөнгөд хэний ч зөвшөөрөлгүй халдах тусгайлсан эрхийг эдэлдэг учраас тэдэнд мэдлэг, мэргэжил, мэргэшил, ёс суртахууны хувьд өндөр шаардлага тавигдах тийм эрх зүйн орчинг сайтар бий болгох цаг хугацаа болсон гэж миний бие үзэж байна. Цаашид шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг хууль эрх зүйн орчинд сайжруулан баталгаажуулах нь зүйтэй юм.

1. Шийдвэр гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг шүүх гүйцэтгэж байхаар бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож зарчмын хувьд ял эдлүүлэх байгууллагаас салгах, цаашид төсөв, санхүүгийн хувьд бие даасан хараат бус байдлыг бий болгон бэхжүүлэх үүднээс хувийн хэвшилд ажиллагаа явуулах эрх олгох боломжийг судлан хуульчлах нь зүйтэй санагдаж байна. Нөгөө талаар Төрийн авлага барагдуулах чиг үүрэг гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэлийн байгууллага бий³⁸ болгох хууль эрх зүйн орчныг судлан цаашид энэ талаар тусгайлсан хууль, тогтоомж гаргах шаардлагатай гэж үзэж байна.

2. Хувийн шийдвэр гүйцэтгэгчид тавих мэргэшлийн болон ёс суртахууны шаардлагыг өндөржүүлж, тэднийг шилж

сонгох, эрх олгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн тогтолцоог бий болгох нь судалбал зохих асуудлын нэг мөн гэдэгт эргэлзэхгүй байна.

3. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааны талаархи Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Иргэний хуульд заасан заалтууд хоорондоо зөрчилдөх, амьдрал практик дээр хэрэгжихгүй байх тохиолдол цөөнгүй гарч байна. Ялангуяа төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд шүүхэд үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үнэ, үнэлгээтэй холбоотой гомдол гаргахад анхан болон давах, хяналтын шатны шүүгчид дээрх хуулийн заалтуудыг өөрсдийн дотоод итгэлд тулгуурлан ижил төрлийн нэхэмжлэлийг өөр өөрөөр шийдвэрлэх тохиолдол цөөнгүй гардаг. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д “дараахь тохиолдолд эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ” гээд 37.2.2-д Төлбөр төлөгч, төлбөр авагч, өмчлөгч Иргэний хуулийн 177.1-д заасны дагуу тохиролцоогүй бол үл хөдлөх эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ гэж заасан. Жишээ дурьдвал: Барьцааны байр 4 хүний эзэмшилд бүртгэлтэй байгаа тохиолдолд эзэмшигчээс заавал үнэлгээний талаар санал авна гэсэн үг. Санал тохиролцуулах ажиллагааг явуулаагүй бол шүүхээс үнэлгээ хүчингүй болгон шийдвэрлэдэг тул эзэмшигч, төлбөр төлөгч нар нь үнийн санал өгөхгүй, зориуд зайлсхийх тохиолдол гарч болзошгүй бөгөөд энэ шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болох тул үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шууд шинжээч томилон гүйцэтгүүлдэг байх нь илүү боломжтой хувилбар юмаа.

“Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын талаар”

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Шүүхийн шийдвэр

³Legalinfo.mn Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1 дэх хэсэг

⁴Legalinfo.mn Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37 дугаар зүйл 37.2 37.2.2 дэх хэсэг

гүйцэтгэх байгууллага улсын төсвөөс санхүүжинэ”, “Шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан урамшууллаас санхүүжүүлнэ” гэж зааснаар шийдвэр гүйцэтгэгч төрийн албан хаагчийн хувьд төрөөс цалинжиж, харин бусад бүх бүх зардлаа урамшуулалаас санхүүжүүлж байна. Гэтэл шийдвэр гүйцэтгэгчийн зардлыг санхүүжүүлж байгаа эх үүсвэрийг “урамшуулал” хэмээн нэрлэж байгаа нь хир зэрэг нийцтэй байна вэ гэдгийг эргэж харах шаардлага тавигдаж байна.

Хуульд хэрэглэгдэж байгаа нэр томъёо нь төрөөс тогтоосон байдгаараа албан ёсны шинжтэй боловч утга агуулгын хувьд иргэдэд ойлгомжтой, тодорхой, нэг л утгыг илэрхийлж байх ёстой.

Жирийн иргэд шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олголоо гэвэл шийдвэрийг биелүүлээд дууссаны дараа сайн ажилласныг урамшуулан олгож байгаа хөлсийг нь өглөө гэж ойлгоно. Гэтэл энэхүү урамшууллыг төлбөр авагч нар ойлгохдоо 100% шийдвэр гүйцэтгэгч авдаг гэж ойлгодог гэтэл уг хөрөнгөөр болзошгүй эрсдлийн сан, албаны байр, цахилгаан дулаан, тоног төхөөрөмж, урсгал зардал, сургалт семинар, томилолт зэрэгт шаардагдах зардлыг санхүүжүүлж байгаа тул энэ нь шийдвэр гүйцэтгэгчид бүрэн хэмжээгээр хүрч байгаа мөнгөн хөрөнгө биш юм. Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал” хэмээн нэрлэгдэн зохицуулагдсан байна. Иймд шийдвэр гүйцэтгэлийн албаны санхүүжилтийг бий болгож байгаа урамшуулал гэдэг нэр томъёог бодит байдалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

“Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглох талаар²³” Гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөс төлбөр авагчид олговол зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон

хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, захирамж, шүүхээс баталгаажуулсан мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас зэрэг багтаж байхаар хуульчилжээ.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4-д үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн, ажилтныг өмнө гүйцэтгэж байсан ажил албан тушаалд эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй, албадан гүйцэтгэх тухай мэдэгдлийг хүлээн авсан боловч шийдвэрийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч ажилтны ажилгүй байсан хугацааны цалин хөлс буюу бага цалин авч байсан бол зөрүүт шийдвэр гарсан өдрөөс эхлэн шийдвэр гүйцэтгэх хүртэл хугацаанд шийдвэрийг гүйцэтгээгүй буруутай албан тушаалтнаас албадан гаргуулах арга хэмжээ авна гэжээ.

Энэ нь шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичиг буюу шүүхийн шийдвэрт заагаагүй төлбөрийг гаргуулах ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ цаашилбал буруутай албан тушаалтныг тогтоож арга хэмжээ авах үүрэгтэй болж байгаа мэт. Үүнээс гадна хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хүсэлтийг шүүх хянан шийдвэрлээд шүүхийн шийдвэрийн дагуу тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлнө гэсэн заалт бий. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэрт заагаагүй, үнийн дүн нь тодорхой бус алдангийг шийдвэр гүйцэтгэгч л албадан биелүүлэх шаардлагатай болж байгаа юм. Эдгээр асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ:

Эцэст нь дүгнэж хэлэхэд Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, ялангуяа энэхүү

ажиллагааны үр дүнгийн талаархи асуудал нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын өмнө байнга тулгарч байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор зөвхөн хуулийн хүрээнд ажиллах нь зүйтэй боловч хуулийн хүрээнд сэтгэдэг байхыг зөвтгөмгүй байна. Тодруулбал иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, цаашдаа баримталбал зохих чиг үүргийг тодорхойлон бүхийл түвшиндээ анхаарч ажиллах цаг болжээ.

Миний зүгээс энэхүү илтгэлийн хүрээнд дараахь асуудалд хууль зүйн үүднээс задлан шинжилгээ хийхийг оролдолоо:

1. Шийдвэр гүйцэтгэгчийг ажлыг мэргэжлийн удирдалгаар хангах үүргийг шүүх гүйцэтгэж байхаар бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож зарчмын хувьд ял эдлүүлэх байгууллагаас салгах, цаашид төсөв, санхүүгийн хувьд бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх үүднээс хувийн хэвшилд ажиллагаа явуулах эрх олгох боломжийг судлан хуульчлах нь зүйтэй санагдаж байна.

2. Хувийн шийдвэр гүйцэтгэгчид тавих мэргэшлийн болон ёс суртахууны шаардлагыг өндөржүүлж, тэднийг шилж сонгох, эрх олгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн тогтолцоог бий болгох нь судалбал зохих асуудлын нэг мөн гэдэгт судлаач миний зүгээс эргэлзэхгүй байна.

3. Үүнээс гадна шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрх зүйн зохицуулалт тусгагдсан боловч шүүхийн шийдвэрийн эцсийн үр дүнг шийдвэрлүүлэх боломж нөхцөл бүрдэхгүй байгааг нь анхаарач нэмэлт байдлаар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

4. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний санал тохиролцуулах ажиллагааг явуулаагүй бол

шүүхээс үнэлгээ хүчингүй болгон шийдвэрлэдэг тул эзэмшигч, төлбөр төлөгч нар нь үнийн санал өгөхгүй, зориуд зайлсхийх тохиолдол гарч болзошгүй бөгөөд энэ шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болох тул үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шууд шинжээч томилно гүйцэтгүүлдэг байх нь илүү боломжтой хувилбар юмаа. Иймд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

5. Шийдвэр гүйцэтгэлийн албаны санхүүжилтийг бий болгож байгаа “Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал” гэдэг нэр томъёог бодит байдалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.